

## ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГО, АРГА ХЭРЭГСЛҮҮД

Н.Батнасан\*, Л.Олонбаяр\*\*, А.Нарандарь\*\*\*,  
О.Нямзул\*\*\*\*, Б.Отгонтулга\*\*\*\*\*

**Хураангуй:** Худалдааг либеральчлах, даяарших чиглэлд олж буй гайхалтай амжилт ололтуудын хажуугаар улс орнууд дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэх арга замаа эрж хайсаар байна. Асуудлыг энэ талаас авч үзвэл, бусад улс орнуудаас илүү сайн хийж чаддаг тэр зүйлээ экспортлох тухай өгүүлдэг харьцангуй давуу талын үзэл баримтлал улс орны эдийн засгийн хөгжлийн бодлогын цөмд байх ёстой.

Энэхүү өгүүллийн гол зорилго нь нэгд, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх онолын үндэслэлийг орчин үеийн онолын үзэл баримтлалаар тайлбарлах, хоёрт, манай орон дахь үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлогыг үнэлж цэгнэх, эцэст нь тулгамдаад буй зарим асуудлыг олж тодруулан хөгжүүлэх шийдлийг олж тодорхойлоход чиглэж байна.

**Түхүүр үгс:** Хамгаалах бодлого, дотоодын үйлдвэрлэл, тарифын зохицуулалт, тарифын бус зохицуулалт

## POLICY OF PROTECTING DOMESTIC INDUSTRIES, ITS INSTRUMENTS

**Abstract:** Despite the impressive success of trade liberalization and globalization, countries continue to find ways to develop their domestic industries. In this regard, the concepts of comparative advantages should be at the heart of the national economic development policy, where it refers to the export activities in which a country performs better than others.

The purpose of this paper is to first explain the theoretical foundation of the protection of domestic industry according to recent theories; secondly, assess the present situation of protectionism in our country; lastly, to raise some actual problems and solutions of its development.

**Keywords:** Protectionism, domestic industry, tariff regulation, non-tariff regulation

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batnasan@num.edu.mn

\*\* ГЕГ-ын ХМССТ-ийн багш, МУИС-ийн Бизнесийн сургуулийн докторант, (E-mail): olonbayar0208@gmail.com

\*\*\* ГЕГ-ын ХМССТ-ийн багш, МУИС-ийн Бизнесийн сургуулийн магистрант, (E-mail): narandari@gmail.com

\*\*\*\* МУИС Бизнесийн сургуулийн магистрант, (E-mail): zulaaoyun5@gmail.com

\*\*\*\*\* МУИС Бизнесийн сургуулийн магистрант, (E-mail): tgntlga@gmail.com

## **Олон улсын худалдааны онол ба үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлого**

Манай орны улс төр, эдийн засгийн хүрээнд олон нийтийн нэлээд түгээмэл байдлаар яригддаг сэдвүүдийн нэг нь үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах тухай асуудал юм. Гэвч үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах тухай асуудлыг ярихдаа эдийн засгийн үр ашгийн тухай асуудлыг мартаж болохгүй.

Нээлттэй эдийн засагтай, жижиг зах зээлтэй орнуудын хувьд эдийн засгийн бүхий л салбаруудыг нэгэн зэрэг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал бөгөөд урт хугацаанд эдийн засгийн хувьд үр ашигтай байж чадах цөөхөн салбарт нөөц хүчээ төвлөрүүлэн, эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлдэг. Рикардогийн харьцангуй давуу талын онолоор бол улс орнууд өөр өөрийн харьцангуй давуу талтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ төрөлжиж, олон улсын худалдаанд оролцох нь үр ашигтай байх ба Хекшер-Олин нарын эрдэмтдийн баталснаар харьцангуй давуу тал нь гол төлөв тухайн улс орнуудын үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн хангалттай холбоотой байна.

Улс орон бүр ажиллах хүчин, газар, капитал гэх мэт үйлдвэрлэлийн хүчин зүйлсээр харилцан адилгүй хэмжээнд хангагдсан байх ба энэ ялгаа нь хүчин зүйлсийн зах зээл дэх үнэд, цаашлаад үйлдвэрлэлийн өртөг зардалд ялгааг үүсгэнэ. Столпер-Самуэльсон нарын эрдэмтдийн баталснаар нээлттэй эдийн засгийн тогтолцоонд экспортын салбар дахь үйлдвэрлэлийн тусгай хүчин зүйлсийг эзэмшигчдийн орлого өсч, импорттой өрсөлдөх салбар дахь үйлдвэрлэлийн тусгай хүчин зүйлсийг эзэмшигчдийн орлого буурдаг. Экспортлож буй бүтээгдэхүүн, түүхий эд нь ХАА-н гаралтай бол газрын эзэд, олборлох үйлдвэрлэлийн гаралтай бол орд газрын лицензийг эзэмшигчид илүү их орлого олно гэсэн үг.

Хожим нь М.Портер хэрвээ улс орон харьцангуй давуу тал бүхий түүхий эддээ түшиглэсэн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж чадвал хямд түүхий эд ашиглаж буй энэхүү кластер нь олон улсын хэмжээнд мөн л өрсөлдөх чадвартай байж болох тухай санааг хөгжүүлсэн.

Олон улсын худалдааны онолын үүднээс авч үзвэл, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай асуудал бол бусдаас илүү өндөр өртөг зардалтай үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой асуудал юм. Тиймээс импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлын талаар ярихдаа түүний эдийн засгийн үр өгөөжийн тухай асуудлыг огтхон ч орхигдуулах ёсгүй. Импортыг орлох үйлдвэрлэлийг стратегийн ач холбогдол бүхий зарим салбарт, тухайлбал хүнс, эрчим хүч, түлш шатахуун, эм гэх мэт бүтээгдэхүүний хувьд хөгжүүлж болох ч хүрээг нь хэт хавтгайруулах нь эдийн

засгийн хөгжилд саад тушаа болох эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, жижиг орон эдийн засгийн хувьд үр ашигтай экспортын үйлдвэрлэл болон үр ашиг муутай импортыг орлох үйлдвэрлэлийн зохистой харьцаанд хөгжүүлэх шаардлагатай гэсэн үг.

Эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллаж чаддаг салбарууд нь үр ашиггүй салбаруудаасаа хэмжээний хувьд илүү том байсан цагт улс орон хөгжих боломжтой. 1990-ээд оноос хойшхи өнгөрсөн 30 гаруй жилийн туршид манай орны эдийн засгийн амьдралд гарсан хамгийн том алдаа бол хөрөнгө оруулахдаа, эдийн засгийн салбаруудаа хөгжүүлэхдээ энэхүү зохистой харьцааг алдагдуулсан явдал юм.

Эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвартай, үр ашигтай ажиллах салбаруудыг олж тодорхойлох нь практикт тулгардаг бэрхшээлтэй асуудлуудын нэг билээ. Төрөл бүрийн бүтээгдэхүүнийг янз бүрийн улс оронд үйлдвэрлэхэд гарах зардал харилцан адилгүй бөгөөд эдгээрийг нэг бүрчлэн тооцох, ийм мэдээллээ улс орнууд өөр хоорондоо солилцох нь онолын хувьд бараг боломжгүй зүйл байдаг. Иймээс эрдэмтэд хялбар аргачлалын тусламжтайгаар харьцангуй давуу талын индексийг ашиглан улс орнуудын хоорондын худалдааг тайлбарлах болсон.

Унгарын математикч Белла Баласса (Balassa, 1965) харьцангуй давуу талын индексийн<sup>6</sup> тухай ойлголтыг анх гаргаж ирсэн бөгөөд энэ индексийг тухайн улсын тодорхой нэг бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний дэлхийн нийт экспортод эзлэх хувийн жинд харьцуулах байдлаар тооцдог. Экспортын харьцангуй давуу талын индексийн тусламжтайгаар улс орнууд ямар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд харьцангуй давуу талтай буюу олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болохыг барагцаалан тодорхойлох боломжтой юм.

Харин бидний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжит хэрэглэгчдийг тодорхойлохдоо улс орнуудын импортын харьцангуй давуу талын индексийг<sup>7</sup> тооцно. Үүнийг тухайн тодорхой ямар нэгэн улсын тодорхой нэг бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний дэлхийн нийт импортод эзлэх хувийн жинд харьцуулах байдлаар тооцоолно.

Ямар нэгэн улс орон эсвэл тухайн бүтээгдэхүүнийг экспортлогч, эсвэл импортлогч байна гэж үзэх нь онолын хувьд буруу юм. Өөрөөр хэлбэл,  $i$  улс  $j$  бүтээгдэхүүний үйлдвэрлэлд экспортын харьцангуй давуу талтай буюу  $RCA_{ij} > 1$  бол энэ бүтээгдэхүүний импортын харьцангуй давуу тал нь  $RMA_{ij}$

<sup>6</sup>  $RCA_{ij} = RXA_{ij} = (x_{ij}/X_i)/(x_{wj}/X_{wi})$  - Revealed comparative advantage or revealed export advantage

<sup>7</sup>  $RMA_{ij} = (m_{ij}/M_i)/(m_{wj}/M_{wi})$  - Revealed import advantage

$< 1$  байна гэж үзэж болохгүй. Ялангуяа бараа бүтээгдэхүүнийг дамжуулан худалдагч буюу реэкспортлогч орны хувьд экспортын болон импортын харьцангуй давуу талын индексийн аль алиных нь утга  $RCA_{ij} > 1$  байх боломжтой. Иймээс практикт худалдааны харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг<sup>8</sup> тооцож ашигладаг. Энэхүү индексийн утга нь нэгд, тухайн барааны бүтээгдэхүүний “цэвэр” урсгал буюу экспорт импортын аль нь давамгайлдаг болохыг, хоёрт, тухайн бараа бүтээгдэхүүний салбар хоорондын худалдааны түвшинг тодорхойлох боломжтой.

Ямар нэгэн улсын тодорхой нэрийн барааны экспортын харьцангуй давуу талын индекс  $RCA_{ij} > 1$  байх нь энэ бүтээгдэхүүнийг улс орон бүрт худалдаалах боломжтой гэсэн үг биш. Экспортын харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнийг зөвхөн ийм бүтээгдэхүүнийг худалдан авах эрэлттэй, тухайн бүтээгдэхүүний хувьд импортын харьцангуй давуу бүхий улс орнуудад худалдах боломжтой юм. Өөрөөр хэлбэл, тухайн бүтээгдэхүүнийг импортлох улсын импортын харьцангуй давуу талын индекс нь мөн  $RCA_{ij} > 1$  байна гэсэн үг.

### **Үндэсний үйлдвэрлэлээ хамгаалан хөгжүүлж буй улс орнуудын туршлага**

Манай орны байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал, далай тэнгисээс алслагдмал байршил, сийрэг тархан суурьшсан хүн ам, цөөн хүн амтай, орлого багатай жижиг зах зээл зэрэг нь үндэсний үйлдвэрлэл хөгжихөд томоохон саад бэрхшээлийг учруулдаг. Сүүлийн жилүүдийн олборлох үйлдвэрлэлийн салбарын өсөлт нь эдийн засгийн бусад салбарын зардлыг өсгөж, экспортод нь сөргөөр нөлөөлөх болов. “Голланд өвчин”-ий нөлөө манай орны эдийн засгийн өмнө тулгамдсан бас нэгэн шинэ сорилт болон гарч ирлээ.

Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд бид байгаль цаг уурын нөхцөл, эдийн засгийн болон экспортын бүтэц, зах зээлийн хэмжээ, газарзүйн байршил зэргээрээ манай оронтой ямар нэгэн байдлаараа ижил төсөөтэй бөгөөд эдийн засгийн хувьд өндөр хөгжсөн Австрали, Канад, Израйль, Чили, Шинэ Зеланд зэрэг орнуудыг сонгон авч, тэдгээр орнуудад үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж буй туршлагыг судлан үзлээ.

#### *Австрали*

Австрали улс нь газарзүйн байршлын хувьд алслагдмал, олборлох үйлдвэрлэл болон ХАА-н салбарууд нь хүчтэй хөгжсөн, уул уурхайн түүхий эд, ХАА-н бүтээгдэхүүний экспортоороо дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг

<sup>8</sup>  $RTA_{ij} = RXA_{ij}/RMA_{ij}$  - Revealed trade advantage

юм. Түүхий эд зонхилсон экспортын бүтэц, түүхий эдээс орох их хэмжээний орлого зэрэг нь тус улсад уул уурхай, ХАА-аас бусад салбарын өрсөлдөх чадварыг сулруулж, хөгжилд нь муугаар нөлөөлж байдаг.

Австрали улс нь буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, тарифын болон татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг. Австралийн Бүтээмжийн комиссын мэдээлснээр 2017-2018 оны санхүүгийн жилд аж үйлдвэрийн салбарт үзүүлсэн тарифын хөнгөлөлт 2.3 тэрбум австрали доллар, татварын хөнгөлөлт 7.3 тэрбум австрали доллар, төсвийн татаас 4.8 тэрбум австрали доллар нийт 14.4 тэрбум австрали доллар орчимд байсан.<sup>9</sup>

Австрали улсын Засгийн газар 2015 онд татварын хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулж, жилийн 2 сая австрали доллараас доош борлуулалтын орлоготой жижиг бизнесийн орлогын албан татварын хэмжээг 30% -иас 28.5% болгон бууруулсан. Улмаар 2016-2017 оны санхүүгийн жилд<sup>10</sup> жилийн нийт борлуулалт нь 10 сая доллараас бага компаниудын төлөх орлогын албан татварын хэмжээг 27.5% болгож бууруулсан бол 2017-2018 санхүүгийн жилд жилийн 25.0 сая доллараас орлоготой аж ахуйн нэгжүүдийг, 2018-2019 оны болон 2019-2020 оны санхүүгийн жилд жилийн 50 сая доллараас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийг уг хөнгөлөлтөд хамруулахаар болжээ. Тус улс 2020-2021 оны санхүүгийн жилээс жилийн 50 сая доллараас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 26.0% болгон бууруулсан бол 2021-2022 оны санхүүгийн жилд 25.0% болгон бууруулахаар төлөвлөж байна. Хөнгөлөлтөд хамрагдаагүй бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд орлогын албан татварын хувь хэмжээг жилийн 30.0%-иар тогтоож, олон жилийн туршид тогтвортой мөрдөж байна.

Төсвийн татаасын 70 гаруй хувийг судалгаа ба хөгжүүлэлт болон жижиг бизнесийг дэмжихэд зарцуулж ирсэн. Татаасыг ХАА-н бус салбарт, тухайлбал байгаль орчныг хамгаалах, инновацийг дэмжих, аж үйлдвэрийг хөгжүүлэх, нэхмэл сүлжмэл, хувцас, гутал, хөнгөн цагаан болон тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжих, бүс нутгийг хөгжүүлэх, мэргэжилтнийг сургаж бэлтгэх чиглэлд буцалтгүй тусламжийн хэлбэрээр зарцуулдаг.

Австрали улс сүүлийн жилүүдэд инновацийг хөгжүүлэх, бизнес эрхлэгчид, түүний дотор жижиг дунд бизнес эрхлэгчид, гарааны компаниудад оюуны өмчийн талаар мэдлэг олгох чиглэлд онцгойлон анхаарч байна. Тус улс жижиг, дунд бизнест оюуны өмчийн асуудлаар дэмжлэг үзүүлэх зорилгоор онлайн платформ байгуулан ашиглах болсон нь нэлээд онцлог арга хэмжээнд

<sup>9</sup> Productivity Commission, *Trade and Assistance Review 2017-18*. <https://www.pc.gov.au/research/ongoing/trade-assistance/2017-18>

<sup>10</sup> Санхүүгийн жил 4-р сарын 1-ээс эхэлдэг.

тооцогдож байна.

### *Канад*

Канад улс нь уул уурхай, ХАА зонхилсон эдийн засгийн бүтэц, хөрш орноос эдийн засгийн хувьд хараат байдал, байгаль цаг уурын нөхцөл байдал зэргээрээ манай оронтой нэлээд төсөөтэй. Сүүлийн жилүүдэд “Голланд өвчин”-ий нөлөөгөөр олборлох үйлдвэрлэлийн бус салбаруудын хөгжилт нь удааширсан.

Канад улсад үндэсний үйлвэрлэгчдийг татаасаар дэмжих явдлыг зохицуулсан хууль эрх зүйн орчин байхгүй боловч холбооны засгийн газар болон мужийн захиргаанаас санхүүгийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй санхүүжилт, татварын хөнгөлөлт, урамшуулал, цалин хөлсний татаас зэрэг хэлбэрээр бизнес эрхлэгчдэд тусалцаа дэмжлэг үзүүлсээр иржээ.

Фрейзерийн хүрээлэнгээс статистик мэдээлэлд үндэслэн Холбооны засгийн газар, муж болон хотын захиргаанаас хувийн хэвшлийн бизнес, засгийн газрын бизнесийн байгууллагууд, хэрэглэгчдэд 1961-2013 оны хооронд 22.4 тэрбум долларын татаасыг олгосон тухай тооцоолол хийжээ. Үүнээс 8.5 тэрбум доллар буюу нийт татаасын 38% -ийг Pratt & Whitney Canada, Bombardier, CAE Inc., and General Motors of Canada гэх зэрэг шилдэг 10 аж ахуйн нэгжид олгосон байна.<sup>11</sup> Фрейзерийн хүрээлэнгээс гаргасан мэдээгээр 2009 онд тус улс ДНБ-нийхээ 1.5% -тай тэнцэх хэмжээний татаасыг аж ахуйн нэгжүүддээ олгожээ.

Канад улс нь тус улсын эдийн засагт онцгой чухал үүрэгтэй нисэх онгоцны үйлдвэрлэл, батлан хамгаалах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан SADI, TRD хөтөлбөр, жижиг бизнесийг дэмжих зориулалттай жижиг бизнесийг санхүүжүүлэх хөтөлбөр (CSBFP)-ийг хэрэгжүүлдэг.

Канадын Бизнес хөгжлийн банк нь бизнесийн хөрөнгө оруулалт, хөгжлийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, ялангуяа ЖДҮ эрхлэгчдэд төлбөрийн уян хатан нөхцлөөр санхүүжилт олгож, санхүүгийн бусад үйлчилгээг үзүүлдэг.

Сүүлийн жилүүдэд тус улсын Засгийн газар өргөн цар хүрээтэй эдийн засгийн бодлого, үүний дотор төсвийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгжийн татварын дарамтыг бууруулах замаар өрсөлдөх чадвартай хөрөнгө оруулалтын орчныг бий болгохыг зорьж байна.

### *Израиль*

---

<sup>11</sup> Milke (2014)

Израйль улс нь цөөхөн хүн амтай жижиг улс боловч жижиг орнууд техник, технологийг хэрхэн амжилттай хөгжүүлж чаддаг болохыг богинохон хугацаанд нотлон харуулж чадсан орон юм.

Израйль улс нь дэвшилтэт технологийг эдийн засгийн өсөлт болон экспортын гол хөдөлгөгч хүч хэмээн үздэг тул үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах хөгжүүлэх бодлогын хүрээнд судалгаа хөгжлийг дэмжих чиглэлд гол үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Ялангуяа харьцангуй давуу тал бүхий салбарууддаа дэвшилтэт техник технологид суурилсан, экспортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг татах, экспортыг дэмжих, захын бүс нутгуудын хөгжлийг дэмжих чиглэлд татварын болон татварын бус урамшууллын тогтолцоогоо зохион байгуулсан. 1959 онд баталсан “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тухай хууль”-ийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг (i) алслагдсан бүс нутаг дахь; (ii) экспортод чиглэсэн үйл ажиллагаатай; (iii) үндэстэн дамнасан корпорациудад олгохоор болж, үүнд ихэнх аж ахуйн нэгжүүд хамрагдах болсон.

Израйлийн засгийн газрын судалгаа, хөгжлийн хөтөлбөрийг тус улсын Аж үйлдвэр, худалдаа, хөдөлмөрийн яамны дэргэдэх Ерөнхий судлаачийн газраас удирддаг бөгөөд тус газрын харьяа Судалгаа, хөгжүүлэлтийн сан нь Израйльд бүртгэлтэй компаниудын судалгаа шинжилгээний төслийн батлагдсан зардлын 50% хүртэл хувийг буцалтгүй тусламжаар санхүүжүүлдэг. Израйль улсын судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардал нь ДНБ-ийх нь 4.4% орчим хувьтай тэнцэж байгаа нь дэлхийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Тус улсын судалгаа, хөгжүүлэлтийн зардлын ихэнх хэсгийг хувийн хэвшлээс санхүүжүүлж байна.

Израйль улс (i) алслагдсан бүс нутаг дахь бизнесийн байгууллагууд, (ii) өндөр цалин хөлс бүхий судалгаа, шинжилгээний байгууллагууд (iii) томоохон үйлдвэрүүдийн газруудад ажил эрхлэлтийн татаас өгдөг.<sup>12</sup>

Израйль улс ХАА-н салбартаа бусад салбаруудтай харьцуулахад илүү өндөр татаас олгож, хамгаалах бодлогыг хэрэгжүүлдэг. Үүнээс гадна аялал жуулчлал, кино урлаг, сэргээгдэх эрчим хүч, санхүүгийн судалгаа шинжилгээний төвүүдэд татаас олгодог байна.

2011 онд татварын урамшууллын бүтцээ хялбаршуулж, жижиг дунд үйлдвэрийн газрууд, уул уурхайн компаниудад урамшуулал олгохоо больсон. Мөн тэргүүлэх салбаруудад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээг 10%-иас 6% хүртэл бууруулах, бусад салбарт 15%-иас 12% хүртэл бууруулжээ.

*Чили*

<sup>12</sup> Invest in Israel online information, “Incentives and benefits: employment grants”. <http://www.investinIsrael.gov.il>

Чили улс нь зэсийн үйлдвэрлэл зонхилсон эдийн засгийн бүтэц, алслагдмал байршил, жижиг зах зээл зэргээрээ манайхтай төсөөтэй улс орнуудын нэг юм. Гэвч олборлох үйлдвэрлэлийн салбар давамгайлсан энэ улсын эдийн засгийн түргэн хурдацтай хөгжлөөс суралцах зүйл бидэнд их бий.

Чилийн эдийн засагт уул уурхайн салбар голлох үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тус улсын байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх боломж нь харьцангуй хязгаарлагдмал шинжтэй. Тус улсад эдийн засгийн шинэ салбарыг хөгжүүлэх, алслагдсан бүс нутагт хөрөнгө оруулалтыг татах, бичил, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, инноваци болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлууд чухлаар тавигддаг тул эдгээр чиглэлд татварын хөнгөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалт ба технологийн хөгжилд санхүүжилт олгох, бизнесийн менежментийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Чили улс бүс нутгуудаа хөгжүүлэх зорилгоор “Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт”, “Алслагдсан бүс нутгийг дэмжих, хөгжүүлэх”, “Чөлөөт бүсийг татвараас чөлөөлөх” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.<sup>13</sup> Чилид 1977 онд байгуулагдсан Iquique (I бүс), Punta Arenas (XII бүс) зэрэг эдийн засгийн чөлөөт бүс бий.<sup>14</sup>

“Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт” хөтөлбөрийн хүрээнд Arica олон Parinacota мужид хөрөнгө оруулж буй компаниудад орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлдэг. Сарын татварын хэмжээ 500 УТМ<sup>15</sup>-ээс давсан хөрөнгө оруулалтын төслүүд энэ хөтөлбөрт хамрагдах боломжтой. Мөн Tierra del Fuego мужийн Porviner, Primavera хотуудад 1992 оноос хойш мөрдөж буй татвар, гаалийн дэглэм 2036 он хүртэл хүчинтэй байна. Энэхүү дэглэмийн дагуу олборлох болон боловсруулах аж үйлдвэр, загас агнуур, тээвэр, аялал жуулчлалын компаниуд бараа, үйлчилгээг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлынхаа ¼-ээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний худалдан авалтыг тухайн орон нутгаас хийсэн бол орлогын албан татвар, НӨАТ, импортын татвараас чөлөөлөгдөх боломжийг олгодог.<sup>16</sup>

Чили улсад бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хэд хэдэн хөтөлбөр байдаг бөгөөд эдгээрийн ихэнхийг Чилийн Эдийн засгийн хөгжлийн агентлаг /CORFO/ удирдаж, хөтөлбөрүүдийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

<sup>13</sup> WTO documents G/SCM/N/186/CHL of 27 October 2009; G/SCM/N/220/CHL of 27 July 2011; and G/SCM/N/253/CHL of 17 February 2014.

<sup>14</sup> Ministry of Finance Decree No. 341 of 1977 and DFL No. 2 of the Ministry of Finance of 10 August 2001.

<sup>15</sup> 2014 онд тогтоосноор 1UTM=76\$US

<sup>16</sup> Law No. 19.149 of 6 July 1992 (last amended in 1992).



Арилжааны банкнаас зээл авах хангалттай баталгаа байхгүй бичил, жижиг аж ахуйн нэгжүүд дээрх хөтөлбөрүүдээс зээл авч болохоос гадна 1980 онд байгуулсан Жижиг аж ахуйн нэгжийн батлан даалтын сан /FOGAFE/-аас зээлийн баталгаа гаргуулан зээл авах боломжтой.<sup>17</sup> Тус сангийн гаргуулсан батлан даалтын ихэнх хэсэг нь худалдаа, тээвэр, харилцаа холбоо, барилга, ХАА, загас агнуурын салбарт ногддог байна.<sup>18</sup>

Чилийн Эдийн засгийн хөгжлийн агентлаг нь загас агнуур, олборлох үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбарт дэмжлэг үзүүлэх олон хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус улс 2012 – 2030 онд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудлыг эрчим хүчний үндэсний стратегийн нь дэмжих ажлыг нэн тэргүүний зорилт болгож, Эрчим хүчний яамнаас CORFO-оор дамжуулан төвлөрсөн нарны цахилгаан станц барих ажлыг хамтран санхүүжүүлэхээр тендэр зарласан. Энэхүү төсөлд ялсан Чилийн болон гадаадын компаниудад 20 сая ам.доллар хүртэл хэмжээний татаасыг олгох юм.<sup>19</sup>

### *Шинэ Зеланд*

Шинэ Зеланд улс нь газарзүйн алслагдмал байршил, жижиг зах зээл, мал аж ахуй зонхилсон эдийн засгийн бүтэц зэргээрээ манайхтай нэлээд төсөөтэй орнуудын тоонд орно. МАА-н салбарыг амжилттай хөгжүүлэн, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр дэлхийд өрсөлдөх туршлагыг зөвхөн Шинэ Зеланд улсаас суралцах боломжтой юм.

Шинэ Зеланд нь дэлхийд хамгийн сайнд тооцогдох бизнесийн орчинтой улс орнуудын нэг бөгөөд тус улс нь бизнес эрхлэх сайн нөхцлийг бүрдүүлж, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг. Шинэ Зеланд улс нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дотроос ХАА-н салбартаа хамгийн бага хэмжээний татаас олгодог улс юм. Энэ байдал 1980-аад оны дунд үеэс худалдааг либеральчлах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн өнөөг хүртэл тогтвортой хадгалагдаж байна.<sup>20</sup>

Тус улсын дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ нь гол төлөв тодорхой салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамаарах ерөнхий үйлчилгээнд зориулагддаг. Тухайлбал, ийм дэмжлэгийг хортон шавьж устгах, мал амьтны өвчлөлийг хянах, байгалийн гамшигт үзэгдлийг арилгах зэрэгт

<sup>17</sup> Decree Law No. 3.472 of 1980.

<sup>18</sup> [http://www.fogape.cl/upload/DOC/Presentaciyn resultados Octubre 2012\(1\).pdf](http://www.fogape.cl/upload/DOC/Presentaciyn resultados Octubre 2012(1).pdf) and information provided by the authorities.

<sup>19</sup> <http://www.corfo.cl/programas-y-concursos/programas/concurso-planta-deconcentracion-solar-de-potencia-csp>

<sup>20</sup> OECD (2013a).

зориулдаг.<sup>21</sup>

Шинэ Зеланд нь бизнесийн чадавхийг дээшлүүлэх, өсөлтийг бий болгох, хөрөнгө оруулалтыг дэмжих, бүс нутгийг хөгжүүлэх, судалгаа ба хөгжүүлэлтийг дэмжих чиглэлээр ихэвчлэн буцалтгүй тусламжийн хэлбэрээр татаас олгодог байна.<sup>22</sup>

Шинэ Зеланд улс 20 орчим жилийн өмнөөс Анхдагч өсөлтийн түншлэл /PGP/ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.<sup>23</sup> PGP хөтөлбөр нь ХАА болон хүнсний үйлдвэрлэл зэрэг анхдагч салбарын үнэ цэн, бүтээмж, үр ашиг, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн судалгаа, инновацийн томоохон хөтөлбөрүүдэд санхүүжилт хийдэг. Албан ёсны мэдээгээр хөтөлбөрийг байгуулагдсан цагаас 2017 он хүртэлх 20 гаруй жилд судалгаа, шинжилгээний төслүүдийг 750 орчим сая ам.доллараар санхүүжүүлсэн. 2025 он гэхэд тус хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн төслүүд нь тус улсын ДНБ-ийг 6.4 тэрбум ам.доллараар өсгөнө гэсэн хүлээлттэй байна.<sup>24</sup>

Шинэ Зеландын Инновацийн агентлаг /Callaghan/ нь бүхий л төрлийн бизнесийн үйл ажиллагааны өсөлтийн шатанд судалгаа, хөгжүүлэлтийн тал дээр дэмжлэг үзүүлдэг. Тус агентлаг бизнесийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай зөвлөхүүдийг аж ахуйн нэгжүүдэд бизнесийн хэлхээ холбоо тогтоох, техникийн шийдэл боловсруулах, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэх ажилд татан оролцуулж дэмжлэг үзүүлдэг. Дээрх зориулалтаар тус агентлагаас жил бүр 160 гаруй сая долларыг дор дурдсан зориулалтаар зарцуулдаг. Үүнд:

- Судалгаа, хөгжүүлэлтэд хөрөнгө зарцуулалт ихтэй бизнесийн байгууллагад зориулан жилд 5 сая доллар хүртэлх буцалтгүй тусламж олгох;
- Судалгаа, хөгжлийн шинэ буюу эсвэл сул хөтөлбөртэй компаниудыг дэмжих;
- Үйлдвэрлэлдээ дэвшилтэт технологи нэвтрүүлж буй бизнесийн байгууллагад олон төрлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ... зэрэг болно.

Дээр дурдсан Австрали, Канад, Израйль, Чили, Шинэ Зеланд зэрэг орнууд нь манай оронтой зарим талаар төсөөтэй боловч нэг хүнд ногдох орлогын хэмжээ өндөр, аж үйлдвэржсэн, хөгжингүй орнуудын бүлэгт хамаардаг улс орнууд юм. Эдгээр орнуудын үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх талаар явуулж буй бодлогыг нэгтгэн дүгнэж үзэхэд дор дурдсан нийтлэг болон

<sup>21</sup> WTO documents G/AG/N/NZL/69, 19 May 2011; G/AG/N/NZL/75/Rev.1, 28 September 2012; G/AG/N/NZL/81, 2 May 2013; and G/AG/NZL/86, 19 May 2014.

<sup>22</sup> WTO documents G/SCM/N/220/NZL, 15 July 2011; and G/SCM/N/253/NZL, 24 June 2013.

<sup>23</sup> WTO document G/SCM/N/253/NZL, 24 June 2013.

<sup>24</sup> "PGP program booklet" Publications Logistics Officer, Ministry for Primary Industries 2016

онцлог зүйлс байна. Үүнд:

- Дээрх орнууд эдийн засгаа тодорхой зорилго, чиглэлтэйгээр хөгжүүлж байна. Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого нь бүтээмжийг дээшлүүлэх, инновацийг бий болгох, өрсөлдөх чадварыг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийг хөгжүүлэх тодорхой зорилгод чиглэсэн байна.
- Эдийн засгийн бүх салбаруудыг хөгжүүлэх бус харин харьцангуй давуу тал бүхий, өрсөлдөх чадвар сайтай цөөн салбарт төвлөрч хөгжих, харьцангуй давуу талдаа тулгуурласан үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх хөгжлийн замыг сонгосон байна.
- Эдгээр орнууд дотоодын зах зээлээ хамгаалахаас илүүтэйгээр бизнесийн орчин нөхцлөө сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бүтээмжээ дээшлүүлэх тал дээр илүүтэй анхаарч байна.
- Татаасыг бүтээгдэхүүн, үйлчилгээнд бус харин судалгаа болон хөгжүүлэлтийг дэмжих чиглэлд, үр ашигтай байдлаар зарцуулж байна. Судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардал нь эдийн засгийн хувьд үр ашигтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох арга зам нь болж чадсан байна.
- Эдгээр орнуудад үйлдвэрлэл харьцангуй сайн хөгжсөн, аж үйлдвэр нь өрсөлдөх чадвар сайтай тул гаалийн тариф нь харьцангуй доогуур түвшинд тогтоогдсон байдаг. 2018 оны байдлаар манай улсын гаалийн тарифын дундаж түвшин 5.26% байсан бол Австралид 0.86%, Канадад 1.47%, Израйльд 1.85%, Чилид 0.49%, Шинэ Зеландад 1.35% байв.

### **Монгол улсын гадаад худалдааны зохицуулалт ба үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлого**

Гаалийн татвар бол үндэсний үйлдвэрлэлийг өрсөлдөөнөөс хамгаалах бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл бөгөөд Монгол улс ДХБ-ын гишүүн орны хувьд гаалийн татварын түвшинг олон талт хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтынхаа хүрээнд тогтоодог.

Үндэсний хууль тогтоомжид зааснаар Монгол улс экспортын ба импортын бараанаас гаалийн татвар хураан авах ба дамжин өнгөрөх бараанаас гаалийн татвар авдаггүй. Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэж ангилна. Хөнгөлөлттэй тарифыг хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр бүхий улс орнууд, нэн буурай хөгжилтэй орны гарал


үүсэлтэй бараанд, харин нэн тааламжтай тарифыг ДХБ-ын гишүүн орнууд болон олон улсын гэрээгээр харилцан тохиролцсон улс орнуудын гарал үүсэлтэй бараанд, ердийн тарифыг дурдсанаас бусад орны гарал үүсэлтэй бараанд ногдуулдаг. Импортын барааны нэн тааламжтай тарифыг олон талт хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтын хүрээнд Улсын Их Хурлаас тогтоох ба хэмжээний хувьд ердийн тарифаас хоёр дахин бага байна.

Олон улсын худалдааны практикт хөнгөлөлттэй тарифыг хоёр талын болон бүс нутгийн хэмжээний чөлөөт худалдааны хэлэлцээр, гаалийн холбоонд нэгдсэн улс орнууд өөр хоорондын худалдаандаа, түүнчлэн ХТЕХ 1994-ийн 1-р зүйлд заасны дагуу нэн буурай хөгжилтэй улс орнуудын гаралтай бүтээгдэхүүнийг импортлох нөхцөлд ашигладаг. Энэхүү нөхцлийн дагуу манай улс Япон улстай байгуулсан ЧХХ-ийн дагуу 2017 оноос тус улсын гарал үүсэлтэй импортын бараанаас, Ази Номхон Далайн Худалдааны Хэлэлцээрт нэгдсэний дагуу 2021 оноос тус хэлэлцээрийн гишүүн БНХАУ, БНЭУ, БНСУ, Бангладеш, Шри Ланка, Лаос зэрэг улсаас гарал үүсэлтэй бараанаас, нэн буурай хөгжилтэй улс орноос гаралтай бараанд хөнгөлөлттэй тарифыг ногдуулж байна.



ДХБ-д элсээгүй, нэн буурай хөгжилтэй орнуудын ангилалд багтаагүй бусад улс орны гаралтай импортын бараанаас гаалийн тарифын тухай хууль тогтоомжийн дагуу ердийн тарифаар гаалийн татварыг хураан авах ёстой. Монгол улс нь ДХБ-д гишүүнээр элсэхдээ дор дурдсан зарим бараа бүтээгдэхүүнээс авах гаалийн татварын хэмжээг тохирсон түвшингээс дээш гаргахгүй байх үүрэг хүлээсэн ба бусад бараа бүтээгдэхүүний хувьд тарифын түвшинг үнийн дүнгийн 20%-иас хэтрүүлэхгүй байх үүрэг амлалт авсан. Монгол улс үүрэг амлалтынхаа хүрээнд 9 төрлийн бараанаас “0” хувь, 40 нэрийн бараанаас 15%, 11 нэрийн бараанаас 10%, 2 нэрийн бараанаас 5%-ийн гаалийн татвар хураан авч байхаар “баталгаажуулсан” ба бусад бараанаас

“баталгаажуулаагүй” гаалийн татвар хураан авдаг.



Гаалийн байгууллагаас улсын төсөвт төвлөрүүлдэг гаалийн болон онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн татвар нь импортын барааны дотоодын үнийг өсгөж, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй улсын төсвийн орлогын багагүй хэсгийг бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилийн дүнгээр гаалийн байгууллагаас төвлөрүүлж буй татварын орлого Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 25-34 хувийг бүрдүүлж байна.

Гаалийн байгууллагаас төсөвт төвлөрүүлж буй орлогын бүрдэл хэсгүүдийг график № 2-т харуулав.

Монгол улс үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлогын хүрээнд дор дурдсан импортын гаалийн татварын өөрчлөлтүүдийг сүүлийн жилүүдэд хийсэн. Үүнд:

- УИХ-ын 2009 оны 3 сарын 12-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шувууны өндөг -15%; цагаан идээ, зөгийн бал ба бусад газар заагдаагүй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн - 5%; төмс -15% байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан.
- УИХ-ын 2011 оны 5 сарын 16-ны 19 дүгээр тогтоолоор сонгино, байцаа, шар лууван, шар манжинд 15%, гурилын импортын тарифыг 7 дугаар сарын 01-нээс 4 сарын 01 хүртэл 15% ба 4 сарын 01-нээс 7 дугаар сарын 01 хүртэл 5%, харин бусад боомтоор импортолсон бол 15% байхаар гаалийн тарифын хувь, хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 2013 оны 5 сарын 24-ний 40 дүгээр тогтоолоор үржлийн мал, амьтны үр хөврөл, ийлдэс гаалийн тарифыг 0% болгож өөрчилсөн.

УИХ-ын 2015 оны 7 сарын 9-ний өдрийн чуулганаар “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг баталсан нь үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжих үйл явцыг шинэ шатанд гаргасан гэж хэлж болно. Шинэчилсэн хуулийн дагуу гаалийн тарифын хувь хэмжээг УИХ тогтоох, түүнчлэн УИХ-аас эрх олгосноор Засгийн газраас тогтоох боломжтой болсон. Ингэснээр дараах Засгийн газрын тогтоолууд гарсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2015 оны 8 сарын 17-ны “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай” 332 тоот тогтоолоор мал амьтны мах, дайвар бүтээгдэхүүн болон цементийн гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээг 5% байсныг 15%-20%, архи, согтууруулах ундааны гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээ 5% байсныг 15%-40% болгон нэмэгдүүлсэн.
- Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-г тогтоох тухай 185 тоот тогтоолоор Хүнсний зарим бүтээгдэхүүн, барилгын материал, модон тавилгын гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээг 5% байсныг 15%-20% болгон нэмэгдүүлсэн.
- УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 27 тоот тогтоолоор Тамхи, тамхи бүтээгдэхүүний гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээг 5% байсныг 20%-30% болгон нэмэгдүүлсэн.
- УИХ-ын 2020 оны 35 тоот тогтоолоор зарим хүнсний ногоо, ургамлын үндэс (төмс, сонгино, байцай, шар лууван, шар манжин, сармис, улаан лооль, өргөст хэмх, тарвас) бүтээгдэхүүний гаалийн нэн тааламжтай тарифын хувь хэмжээг 5% байсныг 20%-30% болгон нэмэгдүүлсэн.

Ийнхүү Монгол улс сүүлийн жилүүдэд тарифын зохицуулалтын хүрээнд дотоодод үйлдвэрлэдэг хүнсний ногоо, аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүнийг гаалийн тарифаар хамгаалахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байна.

Гадаад худалдааны тарифын бус зохицуулалт нь зөвшөөрөл, лиценз, квот, ачилтын өмнөх хяналт шалгалт, эрүүл ахуй, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, худалдаан дахь техникийн болон техникийн бус хориг саадууд, үнийн хяналт, татаас, дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, экспортын даатгал, өрсөлдөөнийг хязгаарлах арга хэмжээ, нийлүүлэлтийн сүлжээн дэх хязгаарлалтууд, худалдаалсны дараах үйлчилгээ, ЗГ-ын худалдан авалт, оюуны өмч, барааны гарал үүсэл, экспортын зохицуулалт өргөн хүрээг хамардаг боловч үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр манай улс цөөн тооны арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Манай улсын гаалийн хууль тогтоомжид зарим нэр төрлийн барааны экспорт, импортыг хориглосон, хязгаарласан заалтууд байдаг боловч эдгээр бараа нь үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх бодлоготой төдийлөн холбоогүй, гол төлөв хүний эрүүл мэнд, байгаль орчны аюулгүй байдлыг хамгаалах, ховордсон амьтан ургамал, түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах зорилготой юм.

Монгол улс ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтынхаа дагууд тарифын бус зохицуулалтыг харьцангуй бага хүрээнд хэрэглэж ирсэн бөгөөд гадаад худалдааны тарифын бус зохицуулалтын хүрээнд манай улс үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах чиглэлд дараахь зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Үүнд:

- Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор 1990-ээд оны дунд үеэс хойш пиво, тамхи, үр тариа зэрэг бүтээгдэхүүнийг лицензээр импортлох, пиво болон тамхинд тариф бүхий квот тогтоох аргуудыг ашиглаж байв.
- Ноос, ноолуур, үр тариа зэрэг ХАА-н зарим төрлийн бүтээгдэхүүнд төсвөөс татаас олгож ирсэн
- Газар тариалангийн салбарт хаврын тариалалт, намрын ургац хураалтад зориулан, түүнчлэн дотоодын ноолуурын үйлдвэрүүдэд ноолуур бэлтгэлд Монгол улсын хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл олгож ирсэн
- Дотоодын хүнсний үйлдвэрүүдийн хэрэгцээг хангах зорилгоор мах, амьд мал амьтны экспортыг хориглож, тодорхой зөвшөөрлийн дагуу экспортлож ирсэн.
- Экспортын бүтээгдэхүүний маркетинг, сурталчилгааг хийх зорилгоор 2018 оноос тодорхой хэмжээний мөнгийг зарцуулах болсон.
- Өрсөлдөөнийг дэмжих зорилгоор үүрэн телефон, цахилгааны эрчим хүчний үнийг төрөөс хатуу зохицуулдаг ба дээд боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, банк санхүү, агаарын болон төмөр замын тээврийн салбарт гадаадын хуулийн этгээдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгогдоогүй.

Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалахад тарифын зохицуулалт чухал үүрэгтэй ба хамгаалалтын үндсэн арга хэрэгсэл болох гаалийн татварыг оновчтой тогтоох аргазүйг бид өмнө хэвлүүлсэн судалгааны бүтээлдээ тусгасан. Харин энэхүү өгүүлэлд бид үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх бодлогын хүрээнд ашиглаж буй тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэрэгслүүдийг цаашид хэрхэн ашиглах тухай асуудлыг өгүүллийн дараагийн хэсэгт судлан

үзэх болно.

### **Монгол улсад үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ**

Эдүгээ манай оронд нүүрлээд буй гадаад өрийн дарамт, гадаад валютын ханшны өсөлт, төлбөрийн тэнцлийн болон төсвийн алдагдал, зээлийн хүүгийн өндөр түвшин, ажилгүйдэл, ядуурал зэрэг олон бэрхшээлтэй асуудлын үндсэн шалтгаан нь үндэсний үйлдвэрлэлийн сул дорой хөгжилтэй холбоотой. Тиймээс гадаад өрийн дарамт өндөр, хөрөнгө санхүүгийн потенциал багатай манай орны хувьд үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх оновчтой бөгөөд зөв арга замыг олж тодорхойлох нь практик ач холбогдол өндөртэй.

Гэвч үндэсний үйлдвэрлэл нь зөвхөн өндөр татвар тогтоосноор хөгждөггүй. Энэ нь тарифын болон тарифын бус бодлого зохицуулалтын хүрээнд зорилго чиглэлтэй, харилцан уялдаатай, урт хугацааны тогтвортой бодлого зохицуулалт, гадаад дотоод хамтын ажиллагаа, талуудын хамтын хүчин чармайлтаар хөгждөг билээ.

Түүнчлэн эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий томоохон асуудлын шийдлийг судалгааны ганцхан өгүүллийн хүрээнд бүрэн тодорхойлох боломжгүй гэдэг нь илэрхий. Тиймээс бид өгүүллийн энэ хэсэгт үндэсний үйлдвэрлэлийг ямар салбаруудад түшиглэн хөгжүүлэх, хөгжүүлэхийн тулд тарифын болон тарифын бус ямар арга хэрэгслүүдийг ашиглах зэрэгт төвлөрөн судлах юм.

Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг авч үзэхдээ бид нэгдүгээрт, урт хугацаанд тогтвортой хөгжих үндэс суурь нь болсон өрсөлдөх чадварын асуудлыг, хоёрт, түүнийг эдийн засгийн хувьд оновчтой бөгөөд үр ашигтай байдлаар хөгжүүлэх боломж арга замыг чухалчлан үзэх шаардлагатай.

Өгүүллийн эхний хэсэгт дурдсанчлан үндэсний үйлдвэрлэл урт хугацаанд оршин тогтнох үндэс суурь болсон өрсөлдөх чадвар нь манай орны үйлдвэрлэлийн харьцангуй давуу талтай шууд холбоотой. Онол ёсоор харьцангуй давуу талд суурилсан үйлдвэрлэл, харьцангуй давуу талтай түүхий эдийг боловсруулах кластер өрсөлдөх чадвартай, урт хугацаанд оршин тогтнох боломжтой.

Бид энэхүү өгүүллийг бичих явцдаа манай улсын нийт экспортын харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг тооцоолсон бөгөөд тооцооллын үр дүнг График №1-т харуулав.

Олон улсын худалдааны төв<sup>25</sup>-ийн 2019 оны статистик мэдээлэлд тулгуурлан манай улсын нийт экспортын 99.78%-ийг эзэлж буй 93 нэр төрлийн


<sup>25</sup> ИТС “Trade map – 2020”



бараа бүтээгдэхүүнийг хамруулан бидний хийсэн судалгаагаар нийт экспортын 97.37%-ийг бүрдүүлж буй 40 нэр төрлийн бүтээгдэхүүний харьцангуй давуу талын индекс 1-ээс өндөр гарч байна.

Нийт экспортын дийлэнх хэсгийг буюу 37.97%-ийг олборлох үйлдвэрлэлийн гаралтай металлын хүдэр ба баяжмал, 45.57%-ийг эрдэс түлш, 6.40%-ийг цэвэршүүлсэн зэс, хагас боловсруулсан алт зэрэг олборлох үйлдвэрлэлийн гаралтай эцсийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Эдгээр нь нийт экспортын 89.94%-ийг бүрдүүлж байна.

Зураг №1. Монгол улсын экспортын бүтэц ба харьцангуй давуу тал



Малын мах, өөх тос, арьс шир, ноос, ноолуур, ноолууран сүлжмэл болон оёмол бүтээгдэхүүн нийт экспортын 7.82%-ийг бүрдүүлж байна. Харин газар

тариалангийн гаралтай бүтээгдэхүүн нийт экспортын 0.21%-ийг, хүнсний бүтээгдэхүүн 0.09%-ийг тус тус бүрдүүлж байна. Модон эдлэл, барилгын материал, химийн бодисын экспорт нийт экспортод 0.06%-ийг, рээкспорт 1.67%-ийг тус тус эзэлж байна.

Хэдийгээр манай улсын гадаад худалдааны тэнцэл сүүлийн жилүүдэд сайжирч байгаа /Зураг №2/ боловч экспортын бүтцэд олборлох үйлдвэрлэлийн болон ХАА-н түүхий эд хэт давамгайлах байдалтай болсон. Манай орны хувьд цаашид экспортын бүтцийг сайжруулах асуудалд онцгойлон анхаарч, түүхий эдийн олборлолт болон үнийн өсөлтөд тулгуурласан экспортын өсөлтөөс татгалзаж, нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт руу чиглэсэн үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон.



Харьцангуй давуу талын шинжилгээнээс үзэхэд, манай улсын экспортын харьцангуй давуу тал байгалийн нөөцөд тулгуурласан олборлох үйлдвэрлэл, өртөг зардал багатайгаар үйлдвэрлэлээ явуулдаг бэлчээрийн МАА гэсэн хоёр салбарт төвлөрчээ. М.Портерын өрсөлдөх чадварын онолын дагуу цаашид олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг боловсруулах металлургийн үйлдвэрлэл, нефть-химийн аж үйлдвэр, МАА-н түүхий эдийг боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг хамгаалан хөгжүүлэх замаар харьцангуй давуу тал бүхий шинэ салбаруудыг хөгжүүлэх боломжтой юм.

Техник технологийн түргэн хурдацтай хөгжил нь манайх шиг орлого багатай, буурай орны хувьд нэг талдаа хөгжлийн хоцрогдлыг үүсгэж байгаа боловч нөгөө талд хөгжлийн томоохон боломжуудыг үүсгэж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Ялангуяа сүүлийн жилүүдэд дэлхийн автомашины үйлдвэрлэлд цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн эрэлт нэмэгдэж байгаа нь манай улсын

экспортын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болох зэсийн эрэлтийг өсгөх төлөвтэй байна. 2017 онд Олон улсын зэсийн холбооны захилгаар IDTechEx судалгааны байгууллагаас хийсэн судалгаагаар цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл 2017-2027 онуудад 3 сая ширхэгээс 27 сая ширхэг хүртэл 9 дахин, цахилгаан тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлд зарцуулагдах зэсийн хэмжээ 185 мянган тн-оос 1740 мянган тн хүртэл өсөх таамаглалыг дэвшүүлсэн. Уг судалгаанд дурдсанаар дотоод шаталтын хөдөлгүүртэй нэг ширхэг автомашиныг үйлдвэрлэхэд дунджаар 23 кг зэс зарцуулагддаг бол хайбрид хөдөлгүүртэй автомашинд 40 кг, цахилгаанаар цэнэглэдэг автомашинд 60 кг, цэнэглэдэг баттерейтэй автомашинд 83 кг зэс зарцуулагддаг байна.<sup>26</sup> 2020 оны статистик мэдээллээр манай улс нэг тн зэсийн баяжмалыг 1274.5 ам.доллараар, 1 тн цэвэршүүлсэн зэсийг 6148.8 ам.доллараар борлуулсан байна.

Эрдэмтдийн хийсэн судалгаагаар цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн нийт өртөгт хөдөлгүүр дунджаар 10 орчим хувийг эзэлдэг<sup>27</sup> бөгөөд цахилгаан хөдөлгүүр хаана үйлдвэрлэснээс хамаарч дунджаар 3000-6000 орчим ам.долларын үнэтэй. Нэг цахилгаан хөдөлгүүрийг үйлдвэрлэхэд 15-20 кг зэс утас ашигладаг<sup>28</sup> гэж үзвэл, зэсийн үйлдвэрлэлд өртөг хэрхэн нэмэгддэг болохыг бид энэ жишээнээс харж болохоор байна.

Оюутолгойн үйлдвэр төслийн бүрэн хүчин чадлаар ажиллаж эхэлсэн нөхцөлд манай улс дэлхийн зэсийн нийт олборлолтын 3%-тай тэнцэх 0.6 сая орчим тн зэсийн агууламж бүхий 2.4 сая тн баяжмал үйлдвэрлэнэ. Түүнийг өнөөдрийн дэлхийн зах зээл дэх баяжмалын үнээр экспортлоно гэж үзвэл 3.0 тэрбум орчим долларын олох боломжтой. Харин түүнийг боловсруулан цэвэршүүлсэн зэс үйлдвэрлэх нөхцөлд 6.0 тэрбум, зэс утас үйлдвэрлэхэд 9.0 тэрбум, автомашины цахилгаан хөдөлгүүр гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 40-60 тэрбум ам.долларын орлого олох боломжтой юм.

Энэ мэтчилэн төмрийн хүдэр болон коксыг ашиглан чанаржуулсан ган үйлдвэрлэх, нефть болон нүүрсээ боловсруулан нефть химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, МАА-н бүтээгдэхүүнээ боловсруулан хүнс, хувцас хунар үйлдвэрлэх гэх мэт өргөн боломжууд бидний өмнө байна.

Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалан хөгжүүлэхэд сайтар боловсруулсан, тодорхой зорилго чиглэл бүхий урт хугацааны тогтвортой бодлого, бизнесийн

<sup>26</sup> IDTechEx “Copper Intensity in the Electrification of Transport and the Integration of Energy Storage”, ICA., 2017

<sup>27</sup> Robert Kochhan, Stephan Fuchs, Benjamin Reuter, Peter Burda, Stephan Matz, Markus Lienkamp “An Overview of Costs for Vehicle Components, Fuels and Greenhouse Gas Emissions “ 2014

<sup>28</sup> Tesla загварын автомашины жишгээр

тогтвортой орчин нөхцөл, худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, гадаад дотоод хамтын ажиллагаа, техник технологи, чадварлаг мэргэжилтэн гээд олон зүйл шаардлагатай. Энэ бүхнийг уялдуулахад худалдаа хөрөнгө оруулалтын бодлого, тарифын болон тарифын бус зохицуулалт чухал үүрэгтэй юм.

Цаашид бид хэнд, ямар зах зээлд зориулж ямар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой вэ гэдэг тал дээр илүү нарийвчилсан шинжилгээг хийх шаардлагатай. Үүний тулд экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүний жагсаалтаа гаргаж, цаашид тэдгээрийг экспортлох зах зээлүүдээ тодорхойлох шаардлагатай. Экспортын бараа бүтээгдэхүүнийг импортлох боломжтой зах зээлүүдийг тодорхойлохын тулд эдгээр бүтээгдэхүүний импортын харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг улс орон бүрийн хувьд тооцож үзэх шаардлагатай. Энэ нь харьцангуй өргөн хүрээг хамарсан судалгаа болох тул хийхэд амаргүй билээ.

Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх асуудлаар хийсэн олон улсын хэмжээний харьцуулсан судалгааны үр дүн, манай улсаас үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах хөгжүүлэх бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг харьцуулан судалсны дүнд үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих бодлогын хүрээнд цаашид дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх нь тээврийн өртөг зардлыг бууруулах, нэмэгдсэн өртгийг бий болгох, бүс нутгуудыг хөгжүүлэх, ажилгүйдэл ядуурлыг шийдэх гол арга зам юм. Тиймээс улс орны харьцангуй давуу талд тулгуурласан, өрсөлдөх чадвар бүхий үндэсний үйлдвэрлэлийг хамгаалан хөгжүүлэх, улс орныг аж үйлдвэржүүлэхэд чиглэсэн урт хугацааны бодлогыг боловсруулан гаргаж, энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлого арга хэмжээг шат дараатайгаар төлөвлөх;
- Улс орны гадаад өр зээл их, эдийн засгийн потенциал бага байгаа өнөөгийн нөхцөлд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний үйлдвэрлэгчдийг олон улсын өртгийн сүлжээнд нэгтгэхэд чиглэсэн бодлогын багцыг боловсруулах, орлогын албан татвар, НӨТ, онцгой татварыг тогтвортой түвшинд барих, гаалийн татвар тарифын орчныг тогтворжуулахад чиглэсэн бодлого, зохицуулалтыг бий болгох;
- Монгол улсын үйлдвэрлэлийн харьцангуй давуу тал бүхий салбарууд түүний дотор ноос, ноолуур, нэхмэл сүлжмэл, мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдэхүүн, эрдэс түлш, металлургийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд

уялдуулсан болон шаталсан тариф тогтоох, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эдийн тарифыг бууруулах буюу “тэглэх”;

- Аж үйлдвэржилт, хөрөнгө оруулалтын тал дээр хамтран ажиллах нэгдмэл сонирхол бүхий улс орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, аж үйлдвэржүүлэх бүс нутгийн байршлыг оновчтой тодорхойлон эдийн засгийн чөлөөт бүсээр зарлах, ЧХХ-үүдийг эхлүүлэхээс өмнө тооцоо судалгаанд тулгуурлан урт хугацаанд тогтвортой мөрдөх гаалийн тарифын түвшинг оновчтой тооцоолон гаргах;
- Аж үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх асуудалд ул суурьтай хандаж, бүтээгдэхүүнд бус бизнесийн байгууллагын судалгаа ба хөгжүүлэлтэд зориулсан татаасыг олгох, мэргэжилтнийг сургаж бэлтгэхэд туслалцаа үзүүлэх;
- Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлогыг талуудын оролцоотой шийдвэрлэх механизмыг бий болгох, Худалдааны бодлогын зөвлөл, Гаалийн тарифын зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж, мэргэжлийн түвшинд ажиллуулах ... зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

### **Дүгнэлт**

Нээлттэй, жижиг эдийн засаг бүхий улс орны хувьд үйлдвэрлэлийн бүхий л салбаруудыг эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллуулах боломж хязгаарлагдмал байдаг. Импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх зарим нэгэн хэрэгцээ шаардлага байгаа боловч түүнийг хэт хавтгайруулах нь эдийн засгийн хөгжилд тус нэмэр болохоосоо чөдөр тушаа болох магадлал нь өндөр юм. Манай улс эдүгээг хүртэл хэрэгжүүлж ирсэн үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлогоо эргэн харж, экспортод чиглэсэн болон импортыг орлох үйлдвэрлэлийн салбаруудаа оновчтой зөв тодорхойлон, зүй зохистой харьцаанд хөгжүүлэх нь чухал болно. Учир нь импортыг орлох үйлдвэрлэл харьцангуй давуу талд тулгуурлаагүй бол эдийн засгийн алдагдлыг бий болгож байдаг.

Орчин үед улс орнууд үндэсний үйлдвэрлэлийг татвар тарифаар хамгаалах бодлогод төдийлөн өндөр ач холбогдол өгөхөө больж, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь сайжруулахад илүүтэй анхаарах болсон байна. Манай орны хувьд ч үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах уламжлалт арга барилаасаа тодорхой хэмжээгээр татгалзаж, судалгаа ба хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнийг сургаж бэлтгэх ажилд илүүтэй анхаарах шаардлагатай байгаа юм.

Нэмэгдсэн өртөг бүхий эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нь манай орны эдийн засаг, нийгмийн өмнө тулгамдаад буй олон асуудлыг шийдвэрлэх, бүтээгдэхүүний овор хэмжээг багасгах, тээврийн өртөг зардлыг бууруулах гол арга зам тул үүнд анхаарлаа хандууах зайлшгүй шаардлага үүссэн.

Гэхдээ үүнийг тарифын хамгааллыг нэмэгдүүлэх, тарифын бус аргуудыг ашиглан худалдаанд саад учруулах замаар бус харин татвар тарифыг бууруулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ЧХХ, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах, хөрөнгө оруулалтыг татах, олон улсын өртгийн сүлжээнд нэгдэх зэрэг шинэ арга хэлбэрээр хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна.

### **Ашигласан материал**

- [1] IDTechEx “Copper Intensity in the Electrification of Transport and the Integration of Energy Storage”, ICA., 2017
- [2] Invest in Israel online information, “Incentives and benefits: employment grants”. <http://www.investinisrael.gov.il>
- [3] Productivity Commission, *Trade and Assistance Review 2017-18*. <https://www.pc.gov.au/research/ongoing/trade-assistance/2017-18>
- [4] “PGP program booklet” Publications Logistics Officer, Ministry for Primary Industries, New Zealand 2016
- [5] Robert Kochhan, Stephan Fuchs, Benjamin Reuter, Peter Burda, Stephan Matz, Markus Lienkamp “An Overview of Costs for Vehicle Components, Fuels and Greenhouse Gas Emissions “ 2014
- [6] Thomas Osang, Alfredo Pereira. 1996. “Import tariffs and growth in a small open economy”. *Journal of Public Economics* 60 (1996) 45-71.
- [7] William R. Cline & John Williamson, 2008. “*New Estimates of Fundamental Equilibrium Exchange Rates*”. Policy Briefs PB08-7, Peterson Institute for International Economics.
- [8] Warner Max Corden. 1966. “*The Structure of a Tariff System and The Effective Protective Rate*”. *Journal of Political Economy*. Vol 74. 1966/6/1.p 221-237
- [9] Warner Max Corden. “*Booming sector and de-industrialization in a small open economy*” *The economic journal*. Vol 92. 1982/12/1. p825-848
- [10] William Cline, et.al., *Trade Negotiations in the Tokyo Round: A Quantitative Assessment*, Washington, D.C., Brookings Institution, 1978.

- [11] Гаалийн Ерөнхий Газар. 2000-2020 он. “Гадаад худалдааны барааны статистик 1999-2018”. Улаанбаатар
- [12] Үндэсний Статистикийн Хороо. 2000-2020 он. “Монгол улсын статистикийн эмхэтгэл” 1999-2019. Улаанбаатар
- [13] WTO documents G/SCM/N/186/CHL of 27 October 2009; G/SCM/N/220/CHL of 27 July 2011; and G/SCM/N/253/CHL of 17 February 2014.
- [14] WTO documents G/AG/N/NZL/69, 19 May 2011; G/AG/N/NZL/75/Rev.1, 28 September 2012; G/AG/N/NZL/81, 2 May 2013; and G/AG/NZL/86, 19 May 2014.
- [15] WTO documents G/SCM/N/220/NZL, 15 July 2011; and G/SCM/N/253/NZL, 24 June 2013.
- [16] WTO document G/SCM/N/253/NZL, 24 June 2013.